

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах	MNS 6260 : 2011
Growing seeds, cultivation and nursing in lawn area	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлахад хамаарна.

2 Нэр томъёо, тодорхойлолт

2.1

Үрийн амьдрах чадвар

Нийт үрийн дотор амьд үрийн эзлэх хэмжээ

2.2

Үрийн цэвэршилт

Шинжилж байгаа хэсэг үрэн дэх тухайн үндсэн ургамлын цэвэр үрийн жинг хувиар илэрхийлэх

2.3

Үрийн соёололт

Тодорхой хугацаанд хэвийн хөгжилтэй соёо ургах чадвар.

2.4

1000 үрийн жин

1000 ширхэг үрийн хэмжээ.

3 Ангилал

3.1 Зүлэгний үрийн соёололт, амьдрах чадвар, цэвэршилт гэсэн үзүүлэлтүүдийг үндэслэн үрийг тариалалтын чанараар ангилна.

- Нэгдүгээр зэрэг.
- Хоёрдугаар зэрэг.
- Гуравдугаар зэрэг.

3.2 Дээрх үзүүлэлтүүдээр стандартын шаардлага хангаагүй үрийг стандартын бус үр гэнэ.

4 Зүлэгжүүлэх талбайг бэлтгэх

4.1 Зүлэгжүүлэх талбайг явган хүний замын түвшинээс 5 см доор байгуулна.

MNS 6260 : 2011

4.2 Шинээр ашиглалтад орсон барилгын ойролцоох талбай болон мод, сөөг тарьсан талбайг зүлэгжүүлэхдээ барилгын хаягдал, чулуу, хайрга, хогийг зөөж талбайгаас зайлуулна.

4.3 Хөрсийг 15-аас 20 см гүн хагалж, хайрга чулууг цэвэрлэж, үлдсэн шороог буталж, зөөллөнө.

4.4 Хангахгүй хар хүрэн хөрсийг 25 мм х 25 мм нүхтэй шигшүүрээр шигшиж, ургамлын үндэс бусад хольцоос цэвэрлэнэ.


4.5 Шигшсэн элс, хар шороог 1:2 харьцаагаар хольж өнгөн хөрс бэлтгэнэ.

4.6 Зүлэгжүүлэх талбайд бэлтгэсэн хөрсийг 20 см зузаан дэвсэж, гадаргууг булдаж, нэгэн жигд тэгшилнэ.

4.7 Талбайг засаж бэлтгэсний дараа 10-аас 20 см гүнд нэвтэртэл усална.



а



б



в

1-р зураг. Үр тарих арга

а) Талбай тэгшлэх

б) Талбай үр тарих бүдүүвч

в) Үрлэх байдал

4.8 Зүлэгжүүлэх 1 м^2 талбайн хөрсөнд 0,5-аас бууц 1 кг, азот 45 г, кали 25 г-ийг хольж өгнө.

5 Үр тарих

5.1 Зүлэгний үрийн чанарын үзүүлэлт 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Олон наст ургамлын үрийн чанарын зэрэг

1-р хүснэгт

Д/д	Ургамлын нэр	Үрийн чанарын зэрэг	Бүх жинд үндсэн таримлын эзлэх хувь (%)	Бусад ургамлын үр (г)	1 кг үрэнд байх хог ургамлын үр (ш)	Соёололтын доод хэмжээ (%)
1	Нугын биелэг өвс	I	95,0	0,5	500	75
		II	85,0	2,0	4000	65
		III	75,0	4,0	12000	50
2	Улаан ботууль	I	97,0	0,5	250	90
		II	92,0	1,5	1000	85
		III	85,0	3,0	300	75
3	Саман ерхөг	I	95,0	0,5	500	90
		II	90,0	2,0	2000	80
		III	80,0	3,0	7000	65
4	Соргүй согоовор	I	95,0	0,5	500	90
		II	90,0	2,0	2000	80
		III	80,0	3,0	8000	65
5	Мөлхөө хиаг	I	95,0	0,5	500	30
		II	90,0	2,0	2000	80
		III	80,0	3,0	6000	65
6	Шар царгас	I	97,0	0,5	4500	85
		II	94,0	1,0	2500	75
		III	90,0	3,0	5000	60

5.2 Үр тарихын өмнө соёололт, амьдрах чадвар, цэвэршилт, 1000 үрийн жинг тодорхойлно.

5.3 1м² талбайг зүлэгжүүлэх үрийн хэмжээг 2-р хүснэгтэд үзүүлэв.

1м² талбайд тарих үрийн хэмжээ

2-р хүснэгт

№	Ургамлын нэр	Орос нэр	Латин нэр	Үрийн хэмжээ (г)
1	Нугын биелэг өвс	Мятлик луговой	Poa pratense	13,5 - 18,0
2	Улаан ботууль	Овсяница красная	Festuca rubra	21,0 - 24,0
3	Саман ерхөг	Житняк гребенгатый	Agropyron cristatum	10,5 - 16,5
4	Соргүй согоовор	Костер безостый	Bromus inermis	21,0 - 30,0
5	Мөлхөө хиаг	Пырей ползучий	Agropyron repens	22,5 - 24,0
6	Шар царгас	Люцерна желтая	Medicago falcate	21,0 - 27,0
7	Галуун гичгэнэ	Лапчатка гусиная	Potentilla anserina	8,0

6 Тарих шаардлага

6.1 Хотын ногоон байгууламжийн мод, сөөг, цэцэгт байгууламжтай, усан сан, оргилуур бүхий том цэцэрлэгийн сул задгай талбайг зүлэгжүүлэхэд согоовор, ботууль, биелэг өвс

6.2 Мод, сөөг, цэцгийн мандал, тоглоомын талбай, явган зам бүхий цэцэрлэгт гудамж, орон сууцны барилгын хооронд ерхөг, согоовор

6.3 Албан байгууллагын орчим, хотын төв хэсэгт ботууль болон гоё үзэмжтэй ургамлыг тасралтгүй цэцэглэж байхаар тооцоолж тарина.

6.4 Хажуу, налуу газарт хөрс хучигч галуун гичгэнэ

MNS 6260 : 2011

6.5 Хотын доторх эрэг жалга, судгийн эргээр царгас, хиаг

6.6 Биеийн тамирын талбай, цэнгэлдэх хүрээлэнд галуун гичгэнэ таривал зохино.

6.7 Зүлэгжүүлэх талбайд олон наст ургамлын үрийг дангаар буюу хольж тарина.

6.8 Үрийг салхи багатай, тогтуун өдөр талбайд жигд цацаад, хөнгөн хөрсөнд 3 см, дунд зэрэг хөрсөнд 2 см, шавранцар хөрсөнд 1 см зузаан хучина. Шүдний хооронд 7-оос 8 см зайтай тармуурыг 2 см хүртэл гүн ортол самнаж ховилд нь үрийг цувуулж хийгээд гадаргууг элсээр хучина. Үр тарьсны дараа хавтгай банз модоор булдаж, зөөлөн шүршиж услана.

6.9 Зүлэгний ургамлын үрийг мод, сөөг тарьсны дараа 5-р сарын 2-р 10 хоногоос 6-р сарын 30-нд багтааж тарина.

6.10 Мод, сөөг тарьсан тогоонд зүлэгний ургамлын үр тарихгүй.

7 Зүлэгний арчилгаа

7.1 Тарьсан үрийг соёолтол нь хөрсний 5-аас 10 см-ийн гүнд тогтмол чийгтэй байлгана. Усалгааг өдөр бүр өглөө, оройн сэрүүнд 1 м² талбайд 30-аас 40 литр усаар мананжуулж усална.




2-р зураг. Усалгаанд хэрэглэх багаж хэрэгсэл

Үр соёолсноос хойш 20-оос 30 л ус ноогдохоор бодож, долоо хоногт 2-оос 4 удаа, гандуу үед өдөр бүр өглөө, оройн сэрүүнд усална.

ТАЙЛБАР 1: Зүлэгний ургамлын үр тарьсан талбайг машинаар услахдаа хамгийн нарийн шүршүүрээр зөөлөн усална.

7.2 Цэнэг услагааг 10-р сарын 15-аас 30 хүртэл хугацаанд хийнэ.

7.3 Хавар цас хайлж, газар гэссэний дараа талбайг тармуураар самнаж, хагд, хог шороог цэвэрлэх, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх, үр ургаагүй, халцарсан газрын зүлгийг нөхөн тарих зэргээр арчилна.



3-р зураг. Зүлэгжүүлсэн талбайг цэвэрлэх байдал

7.4 Хог ургамлыг эхний жил үндэстэй нь зулгаан авч зайлуулна.

7.5 Ногоон байгууламжинд тарьсан зүлгийг 14 хоног тутамд 10 см өндөртэй хяргаж тэгшлэхэд бутлалт сайтай өтгөн болж ургана.



4-р зураг. Зүлэг тэгшлэх, хадах багаж

Тайлбар 1: Зүлгийг заасан хэмжээнээс доогуур мөн 8-р сарын 15-наас хойш хадах, шатаахыг хориглоно.

7.6 Хөрсний үржил шимийг сайжруулахын тулд хавар эрт зүлэг ургаж эхэлмэгц нэмэлт бордоог 1 м² талбайд азот 40 г, фосфор 43 г бордож, зөөлөн усална.

ТӨГСӨВ.